

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Лувсандорж	Дугаар	L282
Оршин суугаа аймаг	Хөвсгөл аймаг	Оршин суугаа сум	Ренчинлхүмбэ
Төрсөн газар	Ренчинлхүмбэ сум	Төрсөн он	1915
Ажил мэргэжил	Өндөрнастан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Зөөлөнгийн хүрээ, Төхийн хурал, Ивдийн хурал	Сүм хийдийн дугаар	ХӨРЛ 001, ХӨРЛ 003, ХӨРЛ 002
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 5-р сарын 27	Ярилцлага авсан хүн	Д .Мөнхбат



Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын Зөөлөнгийн хүрээ,
Төхийн хурал, Ивдийн хурал

Мөнхбат: За манай судалгааны баг өнөөдөр Хөвсгөлд аймгийн Ренчинлхүмбэ сумын төв дээр байх одоогоос гурван зуугаад жилийн түүхтэй Зөөлөнгийн хүрээний туурин дээр ирээд байна. Ингээд энэ хүрээний гарал үүсэл хөгжил түүхийн талаар тус сумын өндөр настан 92 настай Лувсандорж гуайтай ярилцлага хийж байна. За Лувсандорж гуай, та одоо хэдэн настайдаа Зөөлөнгийн хүрээнд шавилан суусан бэ?

Лувсандорж: Найман настайгаасаа шавилан суугаад арван долоо хүртлээ суусан.

Мөнхбат: Зөөлөнгийн хүрээний яг одоо үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн цаг хугацааны хувьд таны сонсож мэдсэн зүйлээсээ хэлнэ үү? Хэдий үеэс одоо Зөөлөнгийн хүрээ маань үйл ажиллагаагаа эхэлсэн гэж?

Лувсандорж: Аан?

Мөнхбат: Хэдий үед байгуулагдсан гэж үздэг вэ, Зөөлөнгийн хүрээг?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Лувсандорж Зөөлөнгийн хүрээ юу, анх байгуулагдсан нь уу, тэр юу юм гэлээ....анх байгуулагдсан нь арван зургаадугаар зууны үед л байгуулагдсан юм гэнэ лээ. Тэр тэдэн он гэж байгаагүй. Тэр хүрээ юм гэнэ лээ, яг тэр хэвээрээ байсан юм.

Мөнхбат: Хүрээ хаагдсан он?

Лувсандорж: Хаагдсан он гучин найман он.

Мөнхбат: За хүрээг хаагдсаны дараа бас тодорхой хугацааны дараа тэр гучин найм, гучин есөн онд...?

Лувсандорж: Тэр Богд жанцан гэж, энэ улсууд түлээд хаячихсан юм.

Мөнхбат: Тэр бол 1938 оны хэддүгээр сар гэлээ?

Лувсандорж: Таван сараас эхэлж нураасан юм.

Мөнхбат: Хүрээ хийд бурхан номын үйл ажиллагаа явуулж байх үедээ хэд орчим ламтай байсан гэж одоо түүхэнд үздэг вэ? Лам, дацан, аймаг ?

Лувсандорж: Юу?

Мөнхбат: Лам, дацан, аймаг ? Одоо тэдэн ламтай байсан, ямар дацан аймгуудтай байсан гээд?

Лувсандорж: Арван дацантай , таван аймагтай байсан юм.

Мөнхбат: Мянга гаруй лам...?

Лувсандорж: Өөв?

Мөнхбат: Мянга гаруй лам сууж байсан гэж...?

Лувсандорж: Мянга гаруй ламтай тийм хүрээ байсан.

Д.Мөнхбат: За танд баярлалаа. Таны өгсөн энэ мэдээлэл манай судалгааны багийн ажилд үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна. Та урт насалж удаан жаргаарай.

Мөнхбат: Танай нутагт энэ тэр Мандал гэдэг газар Мандллын хурал гэж бас нэг хурал байсан гэж бүртгэлд байдаг юм, та энэ талаар?

Лувсандорж: Үгүй ээ үгүй.Тэр Мандал гэдэг газар чинь одоо энэ Хойхны, тэнчээ юу яаж байсан юм гэнэ лээ.Анх хүрээ, энэ Дархдын хүрээ гэж нэртэй хүрээ байгуулагдаж эхлэхлээрээ тэнд байгуулсан юм гэдэг байсан юм.Тэгээд зөөгөөд наашхи нь зөөгөөд хүрээ нутгийн хойш гэдэг дээр ирж сүрхий тохижиж тэнд цам мам гарч байсан гэдэг асуудал байж.Тэгээд цамтай ам гэж нэрлэсэн юм.

Мөнхбат: Тэр хурал бол улирлын чанартай л , түр цагийн хурлууд байсан уу?

Лувсандорж: Аа түр түр, түр байлгүй яахав.Тэр үеэ одоо шинэ дотроо юм чинь түр л байвал зохино шүү, мэдээжийн хэрэг.Манай энд чинь энэ хүрээ хийд хөгжсөнөөс хойш улирлын чанартай барахгүй, өдөр тутам хүрж байсан нь цөөн байна. Жасууд бүгдэн дээр нь байрлаад л одоо ингээд хүрж байсан юм.

Мөнхбат: Мандалын хүрээний одоо тэр үлдсэн байгаа туурь гэж юм байна уу?

Лувсандорж: Аан?

Мөнхбат: Мандалын хүрээний одоо туурь байна уу?

Лувсандорж: Суурь байхгүй, мэдэгдэх юм ердөө байхгүй.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мөнхбат: Юу ч байхгүй болсон уу?

Лувсандорж: Байхгүй.

Мөнхбат: Энэ Ренчинлхүмбэ сумын нутагт Төхийн хурал гэж бас газар байсан гэж бүртгэгдсэн байдаг юм?

Лувсандорж: Төх өө?

Мөнхбат: Төхийн хурал?

Лувсандорж: Аа тэр Төхийн. хурал гэдэг чинь ч тэр Төхөд Дугтуй гэлэн лам гэдэг хүн энэ агын буриадаар нэг ороод нэг дуган бариулж.Тэгээд ганцаараа тэнд одоо хурал ном хурж, тэр буриадуудыгаа шүтэж байсан гэдэг юм.Тэгээд одоо тэр Төхөмийн хурал гэж нэрлэсэн юм.

Мөнхбат: Аа жинхэнэ Дархдуудаас бол тусдаа юм байна, тийм ээ?

Лувсандорж: Өөв?

Мөнхбат: Дархдуудад бол хамаагүй юм байна, тийм ээ?

Лувсандорж: Юуг?

Мөнхбат:Тэр Төхийн хурал бол?

Лувсандорж: Өө тэрийг бол тэр хамаагүй.

Мөнхбат: Цаанаас тэр агын буриадын шугамаар буриадууд...?

Лувсандорж: Нэг үгээр хэлбэл нэг олз бариад ирсэн лам л тэр агын буриадаас жаахан юм татахын эрхэнд нэг дуган шиг юм бариулаад тэгээд юу яаж байсан. Тэр нэг их гавиатай юм байгаагүй юм аа.

Мөнхбат: Одоо бол тийм юу байхгүй?

Лувсандорж: Байхгүй ээ.

Мөнхбат: Буурь туурь бол байхгүй, дуганы үлдэгдэл байхгүй?

Лувсандорж: Аа дуганы нь сүүлд нь тэр том Бурдат гэгээн лам яах дээр зэрэг энд дуганыг нь зөөж авчраад Чивээндэнгийн дуган гэж жижигхэн ийм дуган одоо суудаг болсон.

Мөнхбат: Энэ мангай энэ бүртгэл дээр энэ Эвдийн ам гэдэг газар Эвдийн хүрээ гэж анх байгуулагдаж байсан байдаг юм?

Лувсандорж: Өө тэр чинь байсан юм.

Мөнхбат: За Эвтийн хүрээ гэдгийг одоо бид нарын судалж одоо ойлгож мэдэж байгаагаар энэ Зөөлөнгийн хүрээний эх үндэс байжээ гэсэн ийм нэг мэдээ эх сурвалжууд байдаг юм аа.Энэ хэр баттай вэ?

Лувсандорж: Эвдээ, Эвдийг зөөнө гэж энэ Зөөлөнгийн хүрээг Эвд зөөнө энэ тэр гэж урд нь үзэж байсан гэгээн юм гэсэн юм.Тэгэхлээр нь тэр хар нүдэн Жамбуу гуай гэж Эвдийн хүрээний хамгийн том лам нь байсан юм.Тэгээд тэр манай энд ирээд таарахгүй ээ, Зөөлөнгийн хүрээ тэнчээнээ л байх хэрэгтэй гээд очуулаагүй юм.

Мөнхбат: Энэ Зөөлөнгийн хүрээнд маань Түмэн гэлэнгийн хайлан хурж байсан гэсэн үү?

Лувсандорж: Түмэн гэлэнгийн хайланг хурсан юм гэнэ лээ.

Мөнхбат: Тийм үү?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Лувсандорж: Түмэн гэлэнгийн хайлан гэдэг хураад энэ Яргүй гэржэ гандан намжил гэж хийд гэж байсан юм ,анх. Аа тэгээд сүүлд нь Чойванчиг зайсан гэдэг их баян хүн Түмэн гэлэнгийн хайлан гэгчийг хуруулаад тэгээд арван зургаан Найдан Чүгдэг гэдэг босоо бурхан бүтээлгээд тэгэд урдаар энэ тосгоноос Хутаг гэгдэгчинг хүрээ болгосон юм гэнэ лээ.

Мөнхбат: Түмэн гэлэнгийн хайланд хурж байгаа гэлэнгүүд байна ш дээ, ирсэн лам нар?

Лувсандорж: Ээ ер нь яаж мэдэхэв дээ.

Мөнхбат: Тэр ганцхан монгол лам нар байсан уу, энэ Төвдөөс энэ тэр лам нар ирж байсан уу?

Лувсандорж: Хаанаас, монгол монгол .Дандаа монгол лам нар.Монгол гэлэнгүүд байсан байна.Дан гэлэнгүүд байсан байна.Түмэн гэлэн гэдэг маань гэлэн л улсууд байж л дээ.

Мөнхбат: Зөөлөнгийн хүрээнд тийм Төвд лам нар байсан уу?

Лувсандорж: Байгаагүй ээ.Ердөө байгаагүй, Төвд лам нар ердөө байгаагүй.